

**“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 02 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн А.Бакей**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

“Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж, 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хороо хуулийн төсөл санаачлагчдаас урьдчилан саналыг авахад Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 11, Байнгын хороодоос 45, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдээс бүлгээс 76, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Д.Ганбат, С.Оюун нараас 8, Монгол Улсын Засгийн газраас 60, нийт 200 төсөл хэлэлцүүлэхээр санал ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай тогтоолын төслийг боловсруулахдаа:

-Хаврын чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль, тогтоолын төслүүд;

-Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа төслүүдээс холбогдох Байнгын хороод нь эхний ээлжинд хэлэлцүүлэхээр санал болгосон төслүүд;

-Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй боловч Улсын Их Хурлын даргын захирамжаар төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр хугацаа заасан болон зайлшгүй шаардлагатай гэж үзсэн зарим төслүүдийг багтаах гэсэн зарчмыг баримтлан тогтоолын төсөлд 33 төслийг нэр заан тусгалаа.

Тогтоолд зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төслийг ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулахдаа Байнгын хороодын саналыг харгалзах нь зүйтэй гэж үзлээ.

Түүнчлэн одоогоор боловсруулах шатандаа байгаа, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдээгүй хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгаснаас бусад төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэж байх нь зүйтэй гэж үзлээ.

Байнгын хорооны хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төсөл, Худалдааны тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт Төрийн албаны тухай хуулийн төсөл, Казиногийн тухай хуулийн төсөл, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Аудитын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчлийн тухай хуулийн төсөл, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл, "Төрөөс аж үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус нэмэх, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай болон Эдийн засгийн өршөөл үзүүлэх тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан хэлэлцэн батлах боломжтой тул хасах санал гаргасныг Байнгын хороонд хуралдаанд оролцсон гишүүд дэмжлээ.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай, Эдийн засгийн өршөөл үзүүлэх тухай, Өрийн удирдлагын тухай, Зөвшөөрлийн тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар батлаагүй тохиолдолд эдгээр хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар эхний ээлжинд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бүс нутгийн хөнгөлөлтийн тухай хуулийн төслүүдийг нэмэх, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл Гэр бүлийн тухай хуулийн болон Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг хасах санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

"Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

УХА0316

А.БАКЕЙ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай ;

2/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/Монгол Улсын 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;

4/“Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны санхүүгийн нэгдсэн тайлан;

5/“Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

6/Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

7/“Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

8/Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9/“Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

10/Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төсөл;

11/“Төрөөс аж үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

12/Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл;

- 13/Монгол Улсын худалдааны тухай хуулийн төсөл;
- 14/Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- 15/Нягтлан бодох, бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- 16/Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн

төсөл;

- 17/Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төсөл;
- 18/Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл;
- 19/Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад

хуулийн төсөл;

20/"Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

21/Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл;

22/Нийтийн сонсголын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл;

23/Хяналтын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл;

24/Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

25/Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

26/Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

27/Зөрчлийн тухай хуулийн төсөл;

28/Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

29/Монгол Улсын сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл;

30/Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслүүд;

31/Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл;

32/Казиногийн тухай хуулийн төсөл;

33/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

34/бусад.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3. Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Гарын үсэг

Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлсэн шалтгаан болон үр дүнд нь Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлсэн шалтгаан болон үр дүнд нь Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлсэн шалтгаан болон үр дүнд нь Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлсэн шалтгаан болон үр дүнд нь Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлсэн шалтгаан болон үр дүнд нь Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлсэн шалтгаан болон үр дүнд нь Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлсэн шалтгаан болон үр дүнд нь Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.